

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.060.10

Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорхи усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.	MNS 3597 : 1983
Общие требования охраны поверхностных подземных вод от загрязнения минеральными удобрениями	СТ СЭВ 4035-83

БНМАУ -ын Үнэ, стандартын улсын хорооны 1983 оны 226-р тогтоолоор батлав.
1984 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө

Энэ стандарт нь эрдэс бордоог хэрэглэх, тээвэрлэх, хадгалах үед гадаргуугийн ба газрын доорхи усыг эрдэс бордоогоор бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлагыг тогтооно.

1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа гадаргуугийн ба газрын доорхи усыг эрдэс бордоогоор бохирдуулахгүй байх бүх арга хэмжээг авсан байна.

2. Бордоог хэрэглэхдээ шаардагдах бордоо ба бордож байгаа газрын хэмжээ, бордох арга, хугацааг тодорхой заасан төлөвлөгөөг үндэслэх бөгөөд түүний бодит хэрэглээг тусгай журналд тэмдэглэж байна.

3. Унд ахуйн төвлөрсөн хангамжийн зориулалттай, ил далдад эх булгийн ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн болон хязгаарлах бүсийн дотор бүх төрлийн аргаар бордоо хэрэглэхийг хориглоно.

4. Ариун цэврийн хамгаалалтын бүсийн дотор хэрэглэх эрдэс бордоог түүгээр ус бохирдохоос урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хангасан байранд түр хадгалж болно.

5. Усны эх булгийн ариун цэврийн хамгаалалтын болон эрэг орчмын хамгаалалтын бүс болон эрэг орчмын хамгаалалтын бүс, үерлэх талбайд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- бордооны уут, савыг устгах ажиллагаа
- бордоо үйлдвэрлэх болон тээвэрлэхэд ашигласан машин төхөөрөмж, сав боодлыг угааж цэвэрлэх .

6. Ариун цэврийн хамгаалалтын хязгаарлах бүсийн дотор дараах нөхцөлд бордоо хэрэглэхийг хориглоно.

- үргэлжилсэн хур бороотой буюу үерийн үед
- бордоог агаараас цацах

7. Ил задгай усны эх булгийн ариун цэврийн хамгаалалтын хязгаарлах бүсээс гадагш талбайд бордоог агаараас цацах замаар хэрэглэнэ. Салхины хурд 10 м/сек-ээс их байх үед агаараас цацах замаар бордоо хэрэглэж болохгүй.

8. Газрын хөрс хөлдсөн буюу цасаар бүрхэгдсэн үед бордоог хэрэглэхийг хориглоно.

9. Илүүдэл усыг нь усны объектод оруулахад гадаргуугийн ба газрын доорх усыг бохирдуулахаар байвал бордоог усалгааны устай хамт хэрэглэхийг хориглоно.

10. Хатуу ба шингэн бордоог тээвэрлэхдээ цацагдаж гоожихоос хамгаалсан зориулалт бүхий тусгай төхөөрөмжийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

11. Бордоог хадгалахдаа гадаргуугийг ба газрын доорхи усыг бохирдуулахгүй бах бүх нөхцөлийг хангана. Үер усанд автагдсан газарт бордоог хадгалж болохгүй. Бордоо хадгалсан талбайгаас борооны усыг ус нэвтрүүлэхгүй саванд цуглууж, хөдөө аж ахун таримлын бордоонд ашиглана.

12. Бордоогоор бохирдсон машин тоног төхөөрөмж, боодол, савыг усны объектод угаахыг хориглох ба зөвхөн тусгай зориулалтын угаах талбайд цэвэрлэнэ. Угаалтаас гарсан бохир усыг тусгайлан цуглуулж уснц объектод оруулахын өмнө ашиглах буюу цэвэрлэсэн байна.

13. Бордооны боодол савыг ашиглах, устгах, хадгалахдаа гадаргуугийн ба газрын доорхи усыг бохирдуулахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ТӨГСӨВ